



ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/69

Бүрэн сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэн сумын уугуул Гантулгын Алтанбаганад хүн төрөлхтний эв нэгдлийн бэлгэдэл их наадам болох “Токио-2020” олимпд Жүдо +90 килограммын жинд барилдахад нь дэмжлэг үзүүлэхээр 500000 (таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах зардал болох 500000 (таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Ж.Хандсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн болон бусад холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нярав (Н.Мөнх-Учрал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Т.ТҮВШИНБАТ



410500171